



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын II баг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ХОА-2023/02-ШТА-ГА

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Д.Балжинням

Утас: 70432545 Цахим хаяг: Baljinnyamd@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 7043-2545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 7043-2545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар..... 3

Хүснэгтийн товъёг..... 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл4-5

БҮЛЭГ 1: ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ МОНГОЛ УЛСЫН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН БАЙНА6

БҮЛЭГ2: ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ОРОЛЦОГЧИЙГ ШАЛГАРУУЛСАН, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙГ ХЯНААГҮЙ, ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТҮҮД ГАРААГҮЙ БАЙХАД ТАХ -Г ХҮЛЭЭН АВЧ БАЙНА.12

БҮЛЭГ3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА..... 21

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ : ӨМНӨХ ОНУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АУДИТААР ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖИЖ БАЙГААТАЙ ХОЛБООТОЙ ТЕЗ-Д АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДААГҮЙ, ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ, ЧАНАРТАЙ ХИЙГДЭЭГҮЙГЭЭС АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ГОМДОЛ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ШҮҮМЖЛЭЛ ТАСРАХГҮЙ БАЙНА.

ЗӨВЛӨМЖ:.....25

ХАВСРАЛТУУД:.....

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол улсын
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	МУ 2021-2015 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зорилтын хүрээнд	6
Хүснэгт 2	ТЕЗ хүргүүлсэн саналын жагсаалтад ороогүй ТАХ жагсаалт	8
Хүснэгт 3	Төсөл арга хэмжээг төрлөөр харуулсан	9
Хүснэгт 4	Зураг төсөв нь хийгдээгүй 2022 онд эхлэх барилга байгууламжийн жагсаалт	11
Хүснэгт 5	Ашиглалтад орсон ТАХ жагсаалт	14
Хүснэгт 6	Дуусаагүй ТАХ жагсаалт	15
Хүснэгт 7	Эрх шилжүүлсэн ТАХ төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр харуулбал	16
Хүснэгт 8	Он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалт	19
Хүснэгт 9	ОНХО-ын төлөвлөлт	20
Хүснэгт 10	Худалдан авах ажиллагаа	23

Графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Төсөл арга хэмжээний ангилал	7
График 2	2021, 2022 оны ХАА ажиллагааны хэрэгжилтийг харьцуулсан судалгаа	12

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын ерөнхий аудиторын баталсан Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийнэ.
Аудитын зорилт:	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж Аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:
Аудитын хамарсан хүрээ:	• Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх, • Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх, • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх Аудитад Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УИХ-аас 2022 онд батлагдсан 53 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн ИТХ-аас батлагдсан 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн төсвийн захирагчид болон Аймгийн засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сум, байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч гэрээ байгуулсан болон зураг төсөв гүйцэтгэсэн ААН-ийг үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт, ажлын тайлан, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгч байгууллагуудтай хийсэн гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулан, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, Ахлах аудитор Л.Галбадрах, аудитор Д.Балжинням, Ц.Аззаяа, Ц.Бадрал нар 2022 оны 03-р сарын 09-нээс 04-р сарын 19-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Хүндрэл бэрхшээл:

Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, Үндэсний аудитын газарт нэгтгүүлэв.

Аудитын тайланг нэгтгэхэд эрх шилжээгүй хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл салбар, газар, хэлтэст байхгүйгээс аудитад шаардлагатай зарим мэдээлэл, судалгааг олон удаа дутуу гаргаж, иж бүрэн ирүүлээгүй, аудитыг гүйцэтгэх хугацаанд Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаа давхцаж, орон нутагт ажиллах хүчний нөөц дутагдалтай байсан нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

Аудитын тайланд шаардлагатай судалгааг хугацаанд нь иж бүрэн ирүүлээгүй тул хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженер геологийн дүгнэлт зэрэг нь төлөвлөлтийн шаардлага хангаж, хууль батлагдахаас өмнө баталгаажсан эсэхийг ХБТХОХ-ээс ирүүлсэн судалгаанаас дүгнэлт хийх боломжгүй байна.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар 30, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 705, шинээр 664, нийт 6,152.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1369 төсөл арга хэмжээг 1,393.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Уг төсөл арга хэмжээнүүдийн жагсаалтад Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 221,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 53 төсөл арга хэмжээнд 53.2 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 53 төсөл арга хэмжээний 14 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж, 39 төсөл арга хэмжээ шинээр батлагдсан бөгөөд 2022 онд 31 төсөл арга хэмжээ бүрэн дуусахаар, 22 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжихээр төлөвлөгдөн батлагдаж 54.7 хувь буюу 29 төсөл арга хэмжээ нь эрх шилжин хэрэгжиж, 45.3 хувь буюу 24 төсөл арга хэмжээ нь эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

2022 онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтад 19,487.5 сая төгрөгийг зарцуулж 1,177.0 сая төгрөгийг Засгийн газрын 2022 оны 495 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 7/02 дугаар тогтоолын дагуу барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 7/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээнд 2022 онд 1.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж баталсан байна.

2022 оны олгосон улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт санхүүжилтийн 11,993.3 сая төгрөг буюу 61.5 хувийг барилга, байгууламжид, 385.9 сая төгрөг буюу 2 хувийг авто зам, гүүрний ажилд, 1,150.8 сая буюу 5.9 хувийг их засварын ажилд, 5,190.4 сая буюу 26.6 хувийг инженерийн шугам сүлжээний ажилд, 767.1 сая төгрөг буюу үлдэх 4 хувийг бусад төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар олгосон байна.

Ховд аймгийн Төрийн аудитын газраас өмнөх онд “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргад 4, Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад 1, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын төлөвлөлтийн хэлтсийн даргад 2, орон нутгийн Өмчийн газрын даргад 2, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргад 1 зөвлөмж, 1218.5 сая төгрөгийн албан шаардлага, 723.4 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 1: ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ МОНГОЛ УЛСЫН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН БАЙНА.

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь "алсын хараа 2050 монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-той нийцсэн байна.

1.1. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бүсчилсэн хөгжил зорилтын хүрээнд Ховд аймгийг Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, өндөр уулын мал аж ахуй, Өрнө -Дорныг холбосон олон улсын тээвэр, логистик, аялал жуулчлал бүхий ногоон хөгжлийн бүс нутаг болгон хөгжүүлэхээр зорьж байна.

Зорилтын нэгдүгээр үе буюу 2020-2030 оны бүтээн байгуулалтын үеийн зорилтын хүрээнд Ховд аймагт олон улс, бүс болон орон нутгийн чанартай авто замын ажил, Булган хилийн боомтын нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх, бүс нутгийн онцлог, нүүдлийн мал аж ахуйд тохирсон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалт, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ байгуулах ажлууд хийгдэж эхлээд байна.

1.2. Ховд аймагт 2022 онд хэрэгжихээр батлагдсан 53 төсөл, арга хэмжээ нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Монгол Улсын "2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.

Хүснэгт 1. МУ 2021-2015 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, зорилтын хүрээнд

Зорилтын нэр	TAX тоо
Хүний хөгжил	15
Шинжлэх ухаан, инновац	1
Эрүүл мэнд	4
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	8
Эрчим хүч	5
Дэд бүтэц: Зам, тээвэр	5
Дэд бүтэц: Барилга, хот байгуулалт	4
Засаглал	3
Бүс, орон нутгийн хөгжил	8
НИЙТ TAX ТОО	53

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүний хөгжлийн бодлого зорилтын хүрээнд эрүүл мэнд, биеийн тамир спорт, боловсрол, үндэсний бахархал өв соёлын чиглэлээр сургууль, цэцэрлэг, кино болон хөгжимт драмын театр, эрүүл мэндийн төвүүд, спорт заал зэрэг 28, бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийн 22, засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөвт байгууллагын барилга байгууламж 3

нийт 53 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

А.1.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилтыг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг бий болгож байна.

1.3.Ховд аймгийн Засаг дарга, ЗДТГ нь "Алсын хараа-2050" урт хугацааны хөтөлбөр, "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд үндэслэн "Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус баримт бичгүүдээр дамжуулан хүний хөгжлийг дэмжсэн "Стандарттай Шинэ-Ховдын төлөө" хүчээ нэгтгэе урианы дор ирэх жилүүдэд аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийг хурдацтай хөгжүүлэх бодлого, зорилтыг тодорхойлж боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж

ахуй, дэд бүтэц зэрэг бүхий л салбар чиглэлийн бодлого, үйл ажиллагааг тусгаж ХАА-н боловсруулах үйлдвэрийн төв болгон хөгжүүлж, эдийн засгаа тэлсэн бие даасан эдийн засагтай аймаг болох суурийг тавин ажиллах бодлогыг тодорхойлсон байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг дээрх хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэхээс гадна хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулах зорилтын хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу боловсруулж Сангийн яаманд саналаа хүргүүлэн ажилласан байна.

“Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд зорилго, зорилттой уялдсан байна.

Ховд аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, өндөр уулын бүсийн аялал жуулчлалаар тодорхойлж, хөрөнгө оруулалтууд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх, улсын дэд бүтцийн хөндлөн тэнхлэгийн зам, боомтыг барьж дуусгах зорилтын хүрээнд чиглэгдэж эдийн засгийн өсөлт бий болох, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг өөрчлөлтүүд бий болохоор байна.


А.2 АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГЖ НЬ ТӨСЛИЙН САНАЛЫГ ХОЛБОГДОХ АРГАЧЛАЛД ЗААСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР СУДЛАН ШИНЖИЛЖ, ҮНЭЛЖ, ЭРЭМБЭЛЭЭГҮЙ, НЭН ТЭРГҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСЛҮҮДИЙГ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.

2.1. Төсөвлөгдсөн тах-ний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд өмнөх оноос дамжин хэрэгжсэн 66,866.0 сая төгрөгийн 16 ТАХ, тайлант онд шинээр батлагдаж хэрэгжиж байгаа 153,102.9 сая төгрөгийн 37 ТАХ-ний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ батлуулаагүй байна.

Хүснэгт 2. Төсөл арга хэмжээг ангиллаар нь харуулбал :

Хэрэгжиж байгаа 53 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ангиллаар нь авч үзвэл барилга байгууламж 46, их засвар 2, тоног төхөөрөмж 5 байна.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналд тусгаагүй 19 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан нь, төлөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээ батлагдаж байгаа зөрчил байсаар байна.

2.2. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс УТХО-аар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналын жагсаалт гарган харьяа салбарын ТЕЗ-дад хүргүүлсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 2022 онд санхүү, эдийн засгийн шинжилгээ судалгаа хийгдсэн нийт 39561.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 төсөл арга хэмжээг 11 сайдын багцаас УТХО -аар хэрэгжүүлэх саналыг хүргүүлжээ.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгуулалтын жагсаалтад батлагдсан 39 ТАХ-ний 20 төсөл арга хэмжээ буюу 51 хувь нь тусгагдаж, 49 хувийн 19 төсөл арга хэмжээ ТЕЗ -ийн хүргүүлсэн саналын жагсаалтад ороогүй төсөл арга хэмжээнүүдийг жагсаалтад оруулан баталсан байна.

Хүснэгт 2: ТЕЗ хүргүүлсэн саналын жагсаалтад ороогүй ТАХ жагсаалт /сая төгрөгөөр/

Д/д	Харьяа ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилтийн дүн
1	ХХААХҮС	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/	300.0
2	БХБС	Сумын тохижилт /Ховд, Алтай сум/	200.0
3	БХБС	Сумын тохижилт /Ховд, Мөст сум/	200.0
4	БХБС	Сумын тохижилт /Ховд, Эрдэнэбүрэн сум/	200.0
5	БХБС	Сумын тохижилт /Ховд, Дуут сум/	200.0
6	ХХААХҮС	Түүхий эдийн төвийн барилга /Ховд, Мөст сум/	400.0
7	ХХААХҮС	Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	4,800.0
8	ЭХС	Халаалтын зуухны өргөтгөл /Ховд, Зэрэг сум/	600.0
9	ЭХС	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур сүлжүүлэх /Ховд, Жаргалант сум/	795.0
10	ХХААХҮС	Ус шахах тоног төхөөрөмж /Ховд/	150.0
11	БХБС	Багийн тохижилт /Ховд, Жаргалант сум/	200.0
12	ЭХС	Сумын төвийн цахилгаан хангамж /Ховд, Манхан сум/	600.0
13	ЭХС	Тахилт багийн 28.5 км 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /Ховд, Манхан сум/	760.0
14	БХБС	Халуун усны барилга /Ховд, Үенч сум/	200.0
15	БХБС	Халуун усны барилга /Ховд, Ховд, Буянт сум/	390.0
16	БХБС	Цэвэр усны шугам /Ховд, Буянт сум/	200.0
17	ЭМС	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн явуулын амбулаторийн автомашин /Ховд/	450.0
18	БШУС	Сургуулийн барилга, 160 суудал /Ховд, Мөнххайрхан сум/	4,900.0
19	ЦХХС	Үүрэн сүлжээний антен /Ховд/	400.0
НИЙТ ДҮН			15,945.0

Эх сурвалж : ТЕЗ -ийн хүргүүлсэн албан тоот, саналын жагсаалт

ТЕЗ-ийн саналыг харгалзан үзэлгүйгээр төлөвлөж, санхүүжүүлсэн нь орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, хөрөнгө оруулалтын бодлого алдагдах, төлөвлөлтийн шаардлага хангагдахгүй төсөл арга хэмжээ батлагдаж байгаа зөрчил дахин давтагдсаар байна.

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг үндэслэн Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 4.1- т заасны дагуу шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл, их засварын төсөл, шинээр хэрэгжүүлэх төслийн төрлүүдээр эрэмбэлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, их засвар, тоног төхөөрөмжийн саналын жагсаалт гарган publicinvestment.gov.mn цахим системд оруулж байгаа боловч, программын ашиглалт хангалтгүй байна.

Саналыг хуулийн хугацаанд Сангийн яам болон холбогдох газруудад аймгийн Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн боловч хэрэгцээ шаардлагын дагуу бүрэн эрэмбэлэгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж эсвэл мэргэжилтэн нь төслийн саналыг холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, үнэлж, эрэмбэлээгүй.
- Журамд заасны дагуу судалгаа хийж, үнэлж эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлоогүй.

Цаашид Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ыг мөрдөж ажиллахыг зөвлөмжөөр хүргүүлэн ажиллаа.

А.2.3. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаас гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан үүсэж байна.

2.3. Тайлант 2022 онд шинээр хэрэгжих 152,820.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 ажлаас аймгийн ТЕЗ-д 48,872.3 сая төгрөгийн 24 ажлыг эрх шилжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Төсөл арга хэмжээг төрлөөр нь харуулбал /сая төгрөгөөр/

Д/д	ТАХ-ны төрөл	Шилжиж ирсэн		Шилжиж ирээгүй		нийт дүн	
		тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Барилга байгууламж	21	43,116.3	13	103,630.60	34	146,747
2	Тоног төхөөрөмж	3	5,756.0	1	300.0	4	6,056
3	Их засвар	0	0.0	0	0.0	0	0
ТАХ нийт дүн		24	48,872.30	14	103,930.60	38	152,802.90

Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний архитектур, төлөвлөлтийн даалгаврыг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн дагуу аймгийн ерөнхий архитектор баталж, зураг төсөв гүйцэтгэгчид хүргүүлж байна.

Шинээр барих барилга байгууламжийн барилгын ажлын эхлэх зөвшөөрлийг аймгийн ГХБХБГ нь олгохдоо Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйл “Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох”, 28.2¹ дахь заалтын дагуу бүрдүүлэх баримт бичгийн иж бүрдлийг бүрэн хангуулж ажиллаагүй байна

2.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4², 13.1.5³, 13.1.6⁴ дахь заалтуудад заасан журмуудыг мөрдөж ажилласан байна.

Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж байна.

¹ “Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийн хавсаргана”

² Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

³ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

⁴ Улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;

Зураг төслийг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу боловсруулна гэж заажээ.

Тайлант онд хэрэгжих төсөл арга хэмжээний судалгаанаас үзэхэд 46,466,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээний зураг төсвийг, зураг төсвийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалтын зураг төсвийг гүйцэтгэсэн байна.

Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг мэргэжлийн шинжээч оролцуулаагүй тул нотлох боломжгүй байна.

Барилгын зураг төсвийг иж бүрэн боловсруулж, магадлалаар баталгаажуулаагүй нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн баталсан байна. Тус тогтоолын 6.3-т "Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан барилга байгууламжийн зураг төсөлд заавал магадлал хийнэ" гэж заасан.

Аудитын илрүүлэлт

Зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 8,850.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/,
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алаг толгой баг/,
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум/,
- Сумын тохижилт /Ховд, Дуут сум/,

Төсвийн тухай хууль батлагдсаны дараа магадлалаар баталгаажуулж байгаагаас батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, ажлын тоо хэмжээ өөрчлөгдөх, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил бий болох зэрэг эрсдэл үүсэж байна.

1.3.2 Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1⁵, 7.2⁶-д заасан зураг төсөв нь батлагдаагүй 12,591.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуулиар батлуулсан байна.

Хүснэгт 4. Зураг төсөв нь хийгдээгүй 2022 онд эхлэх барилга байгууламжийн жагсаалт / сая.төг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан огноо
		Эхлэх	Дуусах		
1	Сумын тохижилт /Ховд, Дуут сум/	2022	2022	196.00	2022.04.08
2	Түүхий эдийн төвийн барилга /Ховд, Мөст сум/	2022	2022	396.90	2022.04.18
3	Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/	2022	2023	3,135.2	2022.08.25
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/	2022	2023	2,800.5	2022.10.01

⁵ "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл арга хэмжээ нь төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн

⁶ "Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй."

5	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/	2022	2023	1,909.8	2022.10.01
6	Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/	2022	2023	2,449.0	2022.10.01
7	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум/	2022	2023	1,704.1	2022.05.20
НИЙТ				12,591.50	

Эх сурвалж : ХОХБТХ-ээс ирүүлсэн судалгаа

Энэ нь төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр, тойм дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалсан бөгөөд цаашид улсын төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, ТАХ хугацаандаа ашиглалтад орохгүй удааших нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд харьяалах ТЕЗ нар болон Сангийн яам төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүнг магадлалаар баталгаажсан төсвийн дүнтэй уялдуулан хянаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

БҮЛЭГ2: ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ОРОЛЦОГЧИЙГ ШАЛГАРУУЛСАН, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙГ ХЯНААГҮЙ, ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТҮҮД ГАРААГҮЙ БАЙХАД ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.


Б.1.1 Ховд аймгийн Засаг даргад харьяа ТЕЗ нараас 53,219.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хуулийн хугацаанд шилжүүлсэн байна. Үүнээс 1 төсөл хөтөлбөр буюу Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Ховд, Манхан сум) ажил төлөвлөгдсөн хугацаанд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан ч Төрийн хэмнэлтийн тухай хууль, УИХ-ын тодотголоор хөрөнгө оруулалт нь буцаан татагдсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь 2022 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний батлагдсан төлөвлөгөөний дагуу 40 ТАХ-г Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх 40 төсөл, арга хэмжээг 100 хувь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, гэрээ байгуулан ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд ТЕЗ-дын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хугацааг сараар авч үзвэл, 2022 оны 1, 2 дугаар сард 81.8 хувийг, 6 сард 16.4 хувь, 7 сард 1.8 хувийг зохион байгуулсан байгаа нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал хуулийн хэрэгжилт хангагдаж өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.

График 1. 2021, 2022 оны ХАА ажиллагааны хэрэгжилтийг харьцуулсан судалгаа



Б.1.2. ЗУРАГ ТӨСӨВТ МАГАДЛАЛ ХИЙГДЭЭГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах арга хэмжээний хүрээнд зураг төсөв нь хийгдээгүй, зураг, төсөвт магадлал хийгээгүй байхад 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 зүйлийн 29⁷.2.2 дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал :

Зураг төсөв нь 2022 онд хийгдсэн 12,591.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ

Аудитын илрүүлэлт

- Сумын тохижилт /Ховд, Дуут сум, Алтай, Мөст сум
- Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум
- Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/

Зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 13,641,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээ

Аудитын илрүүлэлт

- Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах /Ховд, Жаргалант сум/,
- Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/ ,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/,
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/,
- Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/,
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум/,
- Сумын тохижилт /Ховд, Дуут сум/,
- Түүхий эдийн төвийн барилга /Ховд Мөст сум/

Б.1.3. Захиалагч төсөл арга хэмжээний тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй, тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Тендерийн ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу үнэлгээний хороо байгуулан тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид хүргүүлэн ажиллаж байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.2.2⁸- дахь заалтыг зөрчин ажил гүйцэтгэх гэрээг бусдад шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Боловсрол шинжлэх ухааны сайдын эрх шилжүүлсэн Түлхүүр гардуулах нөхцөлтэй Багшийн хөгжлийн төвийн барилга ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны

⁷ барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁸ Тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

хурлаар “Богоч констракшн ХХК”-тай 2,716.9 сая төгрөгийн гэрээ байгуулах эрхийг захиалагчид хүргүүлсэн байна. Гэтэл захиалагч тухайн төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг “Би эм жи юу ХХК” шилжүүлэн өгсөн зөрчил дутагдал илэрлээ.

Эрх шилжин зохион байгуулагдсан зарим худалдан авах ажиллагаагаар шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27.1.3-д “Тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралт болон тендерийн баримт бичгийн шаардлагуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- Багшийн хөгжлийн төв дуусаагүй ажлын гүйцэтгэл 90 хувьд хүрээгүй, татварын өртэй байхад хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулсан байгаа нь,
- Алтай, Мөст сумын тохижилтын ажлын тендерт оролцогч компани ажлын төсөвт өртөгт зохиогчийн хяналтын зардлыг тооцож тусгаагүй,

Б.2 ТӨСӨВТ ӨРТӨГ НЬ ХҮРЭЛЦЭХГҮЙ ШАЛТГААНААС АЖИЛ НЬ ЗОГССОН СПОРТ ЗААЛНЫ 1 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАСАН 10 ТАХ БАЙНА.

Б.2.1. Бүрэн дууссан барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэхэд төсөвт өртөгт суугдсан зарим ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдал давтагдсаар байна.

Тайлант 2022 онд ашиглалтад орох 23 төсөл арга хэмжээнээс 4,012.2 сая төгрөгийн 10 барилга байгууламж ашиглалтад орж, 4681,8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

Төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй барилга байгууламжийн гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд захиалагчид хугацаандаа ашиглалтад оруулах боломжгүй болсон шалтгаан тайлбараа бичиж хугацааг сунгаж өгөх хүсэлтийг албан тоотоор ирүүлсний дагуу гэрээний хугацааг он дуустал сунгасан байна.

Хүснэгт 5: Ашиглалтад орсон ТАХ жагсаалт

/ сая төг/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртө	Олгосон санхүүжилт	Хүлээн авсан шийдвэр	Төлөв
1	Сумын тохижилт /Ховд, Алтай сум/	200	193.0	2022.09.23 ББКД/27/2022	Бүрэн дууссан
2	Сумын тохижилт /Ховд, Мөст сум/	200	196.2	2022.12.22 ББКД-72/2022	Бүрэн дууссан
3	Сумын тохижилт /Ховд, Эрдэнэбүрэн сум/	200	199.8	2022.11.23 ББКД/54/2022	Бүрэн дууссан
4	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, дэд станц, ухаалаг тоолуур суурилуулах /Ховд, Жаргалант сум/	795	734.8	2022.12.22 ББКД-74/2022	Бүрэн дууссан
5	Сумын ЗДТГ-ын барилгын засвар Буянт сум	200	187.5	2022.08.08 ББКД/22/2022	Бүрэн дууссан
6	Чоно харайхын гүүр /Ховд, Дөргөн сум/	1500	1500.0	2022.09.02 А/33Б/01	Бүрэн дууссан
7	Авто замын засвар, шинэчлэл /Ховд, Чандмань сум/	500	236.6	2022.02.22 03/2022	Бүрэн дууссан
8	Халуун усны барилга /Ховд, Ховд, Буянт сум/	390	390.0	2022.10.25 ББКД/35/2022	Бүрэн дууссан
9	Багийн тохижилт /Ховд, Жаргалант сум/	200	178.3	2022.08.15 ББКД/23/2022	Бүрэн дууссан
10	Сумын тохижилт /Ховд, Дуут сум/	200	196.0	2022.12.19 ББКД/70/2022	Бүрэн дууссан
Дүн		4385	4012.2		

Аудитын хугацаанд ашиглалтад орсон барилга байгууламжийн гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- Алтай сумын тохижилтын ажил: Ажлын төсөвт өртөгт тусгагдсан зам талбайн ажлаас гүйлтийн замыг резин будгаар будаагүй 1,8 сая төгрөг, услалтын системийн усны крант 2,5 сая төгрөг, ус нөөцлөх сав 1ш 5,5 сая нийт 9,8 сая төгрөгийн ажил хийгдээгүй,
- Мөст сумын тохижилтын ажил: улсын комисс хүлээн авсан бодит байдлаар тохижилтын ажил сандал бш, хогийн сав бш хийгдээгүй, зогсоолын цементэн талбай ховхорч шороо чулуу гарсан байдалтай, замын хурд сааруулагч хийгдээгүй зөрчил дутагдал,
- Зэрэг сумын спорт заалны барилга : Гадна фасадын өнгөний хэмжээ, ялгарлыг зургийн дагуу хийгээгүй авчирсан материалдаа тааруулан өндөр нам харилцан адилгүй хийсэн нь барилгын гадна үзэмжийг бууруулсан,

Мөн эрх нь шилжиж ирээгүй үнийн өсөлт, цар тахлаас үүдэлтэй хил гаалиар бараа материалаа оруулж ирж чадахгүй байгаа шалтгаан нөхцөлийн улмаас хугацаандаа ашиглалтад ороогүй цэвэрлэх байгууламж 1, лабораторийн барилга 1, спорт заалны 5 барилга, 1 эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил дуусаагүй үргэлжилж байна.

Хүснэгт 6: Хугацаандаа хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	
		Эхлэх	дуусах
1	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/	2018	2020
2	Спорт заалны барилга, 300 суудал /Ховд, Алтай сум/	2021	2022
3	Спорт заалны барилга, 500 суудал /Ховд, Зэрэг сум/	2021	2022
4	Спорт заалны барилга /Ховд, Жаргалант сум, Бугат, Хайрхан баг/	2020	2021
5	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/	2020	2021
6	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Цэцэг сум/	2020	2021
7	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Ховд, Жаргалант сум/	2021	2022
8	Сумын эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Алтай сум/	2020	2021
НИЙТ ДҮН			

Дээрх ТАХ-нээс төсөвт өртөг нь хүрэлцэхгүй шалтгаанаас ажил нь зогссон спорт заалны 1 барилга байгууламж ашиглалтад орохгүй царцах эрсдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Алтай сумын спорт заал: Үнийн өсөлтийн зөрүүгээс төсөвт өртөг нь нэмэгдэх барилга байгууламжийн жагсаалтад орж төсөвт өртгөө нэмэгдүүлж чадаагүй, одоо барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй гэсэн тайлбартайгаар 2023 оны 4 дүгээр сарын 20 гэхэд ажил нь эхлээгүй ашиглагч байгууллагын хүлээлт үүссэн нөхцөл байдалтай байна.

Б.2.2. Их засварын ажлууд батлагдсан зураг төслийн дагуу хугацаандаа хэрэгжин ашиглалтад орсон байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 1,000,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн барилгын их засвар /Ховд, Булган сум/, Авто замын засвар, шинэчлэл /Ховд, Чандмань сум/-ын ажлууд, тайлант онд Буянт сумын ЗДТГ-ын засварын 187.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлууд зураг төсвийн дагуу хийгдэж дуусаад ашиглалтад орсон байна.

Б.2.3. Зарим нийлүүлсэн тоног төхөөрөмжийн эзэмшигч нь тодорхой бус ашиглалтгүй хадгалагдаж байна.

ХХААХҮС-ын багцаас Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэх 5,456.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 багц ажил хэрэгжих хугацаа болоогүй байна.

ЭМС-ийн багцаас Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн явуулын амбулаторийн автомашин нийлүүлэх 428.0 сая төгрөгийн ТАХ он дамжин хэрэгжихээр гэрээний хугацаа сунгасан байна.

Тайлант онд 145.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ус шахах тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хугацаандаа хэрэгжиж, нийлүүлэгч аж ахуйн нэгж тоног төхөөрөмжөө хүлээлгэн өгсөн боловч ашиглагч байгууллага, иргэн тодорхой бус шалтгааны улмаас гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн агуулахад хадгалагдаж байгааг ашиглагч байгууллагыг тодорхойлж шилжүүлэн өгөх шаардлагатай байна.

2.5 Өмнөх онуудын хөрөнгө оруулалтаар дуусаагүй барилгын жагсаалтад бүртгэгдсэн Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийн ажил 90 хувьтай хэрэгжиж, тоног төхөөрөмжийн шаардлага хангахгүй асуудлаас үүдэн ашиглалтад ороогүй байгаатай холбоотой аудитын явцад Үндэсний аудитын газрын шинжээчийн баг ирж ажиллаа.

Б.3. САНХҮҮЖИЛТИЙН НЭМЭЛТ ГЭРЭЭ БАЙГУУЛЖ БАЙГАА НЬ ХУУЛЬ ДҮРЭМД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.

Б.3.1. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргаж ирүүлсэн тухай бүр системийн дээд байгууллагаас хянаж баталгаажуулж, санхүүжилтийн эрхийг нээж өгсөн байна.

Засгийн газрын шийдвэрээр харьяа сайдуудын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын зарим ТАХ-г хуульд заасны дагуу ХАА-г зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх, тайлагнах эрхийг засаг даргад олгосон байна.

Хүснэгт 7: Эрх шилжүүлсэн ТАХ төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр харуулбал:

2022 онд эрх шилжүүлсэн 29 төсөл арга хэмжээний 63,223.8 сая төгрөгийн санхүүжилтээс ХХААХҮЯ – 3,695.6 сая төгрөг, ЭХЯ - 2,071.7 сая төгрөг, ЗГХЭГ- 321.5 сая төгрөг, ЗТХЯ - 385.9 сая төгрөг, БШУЯ- 5,700.0 сая төгрөг, БХБЯ- 5,199.6 сая

ТЕЗ	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	Санхүүжилт	Зарцуулсан	Барьцаа дансанд төвлөрүүлсэн	Нийт дүн
ХХААХҮЯ	6	11,538.0	3,695.6	3,514.7	180.9	3,695.6
ЭХЯ	3	2,034.3	2,071.8	1,562.8	509.0	2,071.8
ЗГХЭГ	2	433.7	321.5	321.5		321.5
ЗТХЯ	2	1,950.8	385.9	385.9		385.9
БШУЯ	5	15,794.3	5,700.0	5,700.0		5,700.0
БХБЯ	7	11,132.9	5,199.6	5,140.6	59.0	5,199.6
ЭМЯ	2	2,132.3	928.2	500.0	428.2	928.2
СОЯ	2	18,207.5	2,362.0	2,362.0		2,362.0
НИЙТ	29	63,223.8	20,664.5	19,487.5	1,177.0	20,664.5

төгрөг, ЭМЯ - 928.2 сая төгрөг, СОЯ - 2,362.0 сая төгрөг нийт 20,664.5 сая төгрөгийн санхүүжилт авч 19,487.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,177.0 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Б.3.2. 2022 онд хэрэгжиж буй 2 төсөл, арга хэмжээнд нэмэлт гэрээ байгуулсан бөгөөд 1 төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээ хууль, журамд нийцээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Цэцэрлэгийн барилга, 150 ортой /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/-419.7 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулсан байна. Жаргалант сумын Бичигт багт хэрэгжиж буй 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн ажлын хувьд 2,970.4 сая төгрөгөөр төсөвт өртөгтэйгөөр 2022.04.29-ний өдрийн 660/2023 магадлалын дүгнэлттэй байхад Түм дэлгэрэх ХХК тендерт шалгарахдаа 2,800.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан бөгөөд 419.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтад нийцэхгүй байна.

Б.4. ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ, ЧАНАРТАЙ ХИЙГДЭЭГҮЙГЭЭС АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ГОМДОЛ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ШҮҮМЖЛЭЛ ТАСРАХГҮЙ БАЙНА.

Б.4.1. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллага үе шатны хяналтыг хэрэгжүүлж байгаа ч, хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт үр нөлөө багатай байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар он дамжсан, эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын 8 төсөл арга хэмжээний хяналтын зардалд 44.2 сая төгрөгийн санхүүжилтэд аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тухай бүрд нь тусгаж зөрчлийг арилгуулдаг ч явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт үр нөлөө багатай байна.

Эрх шилжиж ирсэн УТХО-ын төсөл арга хэмжээний төсөвт өртгөөс захиалагчийн хяналтын зардалд 376.4 сая төгрөгийг суутган төвлөрүүлж, гүйцэтгэлээр аймгийн ГХБХБГ-нь ТАХ-ны хяналтыг хэрэгжүүлэхэд 135.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн олон угсаатны театрын зураг төсвийн үнэнд 35.0 сая төгрөг олгож авлагаар бүртгэсэн,
- Техник хяналтын дансанд УТХО-ын данснаас гадна ОНХС, ОНХО, Хөшөөт хөгжил сан зэрэг данснуудаас орлого төвлөрдөг ба данс бүрээр тусдаа тайлагнаж, бүртгэл хөтлөхгүй байгаа нь тус данснаас гарч буй зориулалт бус зардлуудыг УТХО-ын захиалагчийн хяналтад хамааруулж авч үзэх боломжгүй байна.
- Өмнөх оны аудитаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын төсөвт өртөг, ажлын тоо хэмжээнд заагдсан зарим ажлууд хийгдээгүйтэй холбоотой 12 төсөл арга хэмжээний 1218.5 сая төгрөгийн алдаа зөрчилд хяналтын дахин хэрэгжүүлж зөрчлийг арилгуулах албан шаардлагын аймгийн засаг дарга, ХБТХОХ-ийн дарга нарт хүргүүлснийг аудитын явцад хянахад хэрэгжилт хангагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын холбогдох заалтыг зөрчиж, барилгын үе шатанд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Б.4.2. Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын аудитаар хяналт муу хэрэгжиж байгаатай холбоотой ТЕЗ-д аудитын байгууллагаас өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага хэрэгжилт хангагдахгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны аудитаар өгөгдсөн 1,218.5 сая төгрөгийн албан шаардлага, 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар 4,951.9 сая төгрөгийн 10 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийгдэж байгаа хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын явцад хяналтыг хэрэгжүүлж байгаа субъектийн үйл ажиллагаанд өмнөх онуудын аудитаар засаж залруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмжүүдийг өгч ажилласаар байхад хэрэгжилт хангагдахгүй алдаа зөрчил давтан гарсаар байгаад дүгнэлт хийн Төрийн аудитын байгууллагын акт албан шаардлагын биелэлтийн журмын дагуу зөрчил илэрсэн ТАХ-г хүлээн авах улсын комисст ажилласан төрийн албан хаагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг ТЕЗ-д хүргүүлэн ажиллаа.

Б.5. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХҮЛЭЭН АВАХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянаагүй, холбогдох дүгнэлтүүд гараагүй байхад ТАХ -г хүлээн авч байна.

Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг аймаг Засаг даргад ирүүлснийг үндэслэн төсөл, арга хэмжээг хүлээж авах ажлын хэсэг, улсын комиссын бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж байна.

Комисс нь холбогдох хууль, дүрмийн дагуу зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтүүд гараагүй байхад ТАХ-г хүлээн авсан зөрчил дутагдал нь Барилгын тухай хуулийн 48.5.-д “Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана” гэсэнтэй нийцэхгүй байна. Тухайлбал :

Аудитын илрүүлэлт

- Комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байхад комиссын дүгнэлт баталгаажсан,
- Үүрэг даалгаврын биелэлтээр өгөгдсөн ажлууд хэрэгжээгүй байхад эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр санхүүжилтийг бүрэн олгож байгаа,
- Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гараагүй байхад үүрэг даалгаврын биелэлтээр улсын комисс ажилласан,
- Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт гараагүй байхад ажлыг бүрэн хүлээн авч комисс ажилласан

Б.5.2. Засгийн газрын тогтоолын биелэлтийг ханган ажиллах шаардлагатай байна.

2022 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 29 төсөл арга хэмжээ байгаагаас 12 төсөл арга хэмжээг бүрэн дуусган хүлээн авч, 1 төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг хэсэгчлэн хүлээн авч, 16 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэн, гэрээний үүргийн биелэлтийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын дагуу тооцон ажиллах шаардлагатай байна.

Он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ

				/Сая төгрөгөөр/
№	Төсөл арга хэмжээ	Төсөвг өртөг	Олгосон санхүүжилт	Дуусах хугацаа
1	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Ховд, Мянгад сум/	2,000.0	500.0	2023.08.21
2	Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/	2,453.8	491.6	2023.10.01
3	Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/	16,021.0	1,870.4	2023.10.30
4	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	3,000.0	1,900.0	2023.08.01
5	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/	5,150.0	200.0	2023.10.04
6	Халуун усны барилга /Ховд, Үенч сум/	200.0	159.7	2023.04.01
7	БОЭТ-ийн явуулын амбулаторийн автомашин	450.0	-	2023
8	Хүнс хөдөө аж ахуйн газар лаборторийн барилга	2,776.5	1,721.8	2023.10.30
9	Түүхий эдийн төвийн барилга /Ховд, Мөст сум/	400.0	352.9	2023.05.08
10	Тахилт багийн 28.5 км 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /Ховд, Манхан сум/	760.0	488.3	2023.05.30
11	Багийн төвийн барилга /Ховд, Буянт сум, Наранхайрхан баг/	250.0	233.9	2024.08.28
12	Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/	3,335.4	1,000.0	2023.08.25
13	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Апагтолгой баг/	2,200.0	800.0	2023.08.20
14	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/	3,261.0	1,800.0	2023.10.24
15	Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Апагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/	9,389.0	5,024.1	2023
16	Цэвэр усны шугам /Ховд, Буянт сум/	200.0	180.9	2023.06.15
Дүн		51,846.7	16,723.6	

Тайлант онд гэрээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг дуусгаж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаагүй 4,681.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл арга хэмжээ байна.

Аудитын явцад газар дээр нь ажил гүйцэтгэх гэрээ хугацаандаа хэрэгжихгүй байгаа шалтгааныг судлахад дараах зөрчлөөс үүдэлтэй байгааг ард иргэд, ашиглагч байгууллагын зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

Аудитын илрүүлэлт

- Гүйцэтгэгч аж ахуйн нэгж мэргэжлийн ажилчдаар дутмаг, сум орон нутгаас мэргэжлийн бус хүн ажиллуулдаг,
- Зааж зааварлах инженер техникийн ажилчин байхгүй хариуцсан нэг даамал л ирдэг,
- Нэг компани зэрэг олон тендер авдаг, дуусаагүй ажил ихтэй тул ажил удааширдаг,
- Техник тоног төхөөрөмж хангалтгүй,
- Ажлаа хугацаандаа эхэлдэггүй зэргээс хөрөнгө оруулалтын ажлын гэрээ хугацаандаа хэрэгжихгүй байна.

Б.5.3. АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН ХӨРӨНГҮҮДИЙГ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭН ДАНС БҮРТГЭЛД ТУСГАЖ, ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээнүүдээс 4 төсөл, арга хэмжээний 582.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээнээс зарим хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Сумын тохижилт /Ховд, Мөст сум/- 196.2 сая төгрөг
- Малчид Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ 4-р багц - Адууны мах боловсруулах тоног төхөөрөмж-62.8 сая төгрөг
- Багийн тохижилт /Ховд, Жаргалант сум/-178.3 сая төгрөг
- Ус шахах тоног төхөөрөмж /Ховд/-145.4 сая

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁹-д гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг баримт бичгийг бүрдүүлэн данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГЗ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР УРСГАЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ БАТАЛЖ САНХҮҮЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙНА.

В.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний 22.7 хувь нь хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулахгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12-р сарын 04-ны өдрийн 5/07 дугаар тогтоолоор ОНХО-ын 2022 оны төсвийг шилжих хөрөнгө оруулалтад 61.5 сая төгрөг, шинээр эхлэх хөрөнгө оруулалтад 302.1 сая төгрөг, төсөл арга хэмжээнд 990.0 сая, өмнө оны дутуу ажлын санхүүжилтэд 33.5 сая, их засварт 1,035.4 сая, нийт 2,422.5 сая төгрөг баталсан байна. Өмнөх онтой харьцуулахад ОНХО-ын гүйцэтгэл 1,890.0 сая төгрөгөөр өссөн байна. Сүүлийн 2 жилийн төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. ОНХО-ын төлөвлөлт (сая.төг)

№	Нэрс	ОНХО /2021/		ОНТХО /2022/	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			2	302.1
2	Тоног төхөөрөмж	6	188.2		
3	Их засвар, тохижилт	10	277.5	13	1035.4
4	Хөтөлбөр арга хэмжээ,	1	30	5	990
5	Өмнөх оны үлдэгдлээс	2	36.8	2	95
ДҮН		19	532.5	22	2422.5

ОНТХО-ын жагсаалтад баталсан ажлуудын 59.1 хувийг их засварт, 9.1 хувийг шинээр эхлэх хөрөнгө оруулалт, 9.1 хувийг өмнөх оны үлдэгдэлд, 22.7 хувийг хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар баталж тоног төхөөрөмжийн ангилалд төсөв батлаагүй байна.

Ховд аймгийн Засаг дарга, ЗДТГ нь "Алсын хараа-2050" урт хугацааны хөтөлбөр, "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд үндэслэн "Ховд аймгийг

⁹ "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-д "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана."

2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг боловсруулан аймагын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд хэрэгжүүлэх 22 хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалтад хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээнд 1,090.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, тухайн шатны төсөв захирагчийн өмчлөлд шилжих боломжгүй, үйл ажиллагааны зардлыг төлөвлөсөн нь эдийн засгийн үр ашиг, ач холбогдол багатай, урсгал зардлыг санхүүжүүлэх, мөн хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэгдэх эрсдэлтэй байна.

В.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр дэмжлэг, урсгалд зардалд 1090.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁰, 6 дугаар зүйлийн 6.4.1¹¹ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2¹²-т заасантай нийцэхгүй байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр 150.0 сая төгрөг
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20 сая мод хөтөлбөр 340 сая төгрөг
- Хогны менежментийг сайжруулах төслийн дэмжлэг /хөтөлбөр/ 200.0 сая төгрөг
- Ковид 19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны зардал 300.0 сая төгрөг
- Аймагын өвсний аюулгүйн нөөц бүрдүүлэлт 100.0

Аймагын ХБТХОХ-ээс хууль, тогтоомжид заасан шалгуур нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй, төлөвлөлтийн шатанд хийгдсэн баримт материал байхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх нөлөө, ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тооцоолоогүй нь үр ашиггүй зарцуулалт хийгдэх эрсдэлтэй байна.

Иймд аймагын эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогыг төлөвлөх үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

В.2.1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Тендерийг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг www.tender.gov.mn цахим сайтаар нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

¹⁰ 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

¹¹ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹² 13.3.2. хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

Тайлант онд аймгийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, их засварын ажилд батлагдсан 2,422.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8, харьцуулалтын аргаар 3 төсөл арга хэмжээг сонгон шалгаруулж, 11 шууд гэрээ байгуулж тендерт шалгарсан оролцогч нартай 2,323.3 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан нь төсөвт 99.2 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцөл бүрдсэн байна. Худалдан авах ажиллагааг хүснэгтээр харуулбал: *График 2*



Нийт баталсан төсөл арга хэмжээнээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Хилийн 0130 дугаар ангийн Баян модны хилийн инженерийн байгууламжийн засвар /Булган сум/, 3-р цэцэрлэгийн барилгын дээврийн засвар, Онцгой байдлын газрын шуурхай штабын байрны засварын ажлуудыг төсвийн захирагч нарт шилжүүлсэн байна.

В.2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл, арга хэмжээнээс 18 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹³ дэх заалтад заасныг зөрчиж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын данснаас 4 арга хэмжээний хүрээнд урсгал зардал гаргасан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг даргын А/320 захирамжаар аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхайн нөхөрлөл, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд 2 сая төгрөг,
- Аймгийн Засаг даргын сумдын иргэдтэй уулзалт хийж санал, хүсэлтийг сонсох, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажилтай танилцах ажлын зардал 7.8 сая төгрөг,
- Аймгийн Засаг даргын А/827 дугаар захирамжаар бүтэн өнчин хүүхдүүдэд “Гэрэлт ирээдүй” тэтгэмж олгоход 8.1 сая төгрөг,
- “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг эрчимжүүлэх, мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулсан аймгийн нэгдсэн зөвлөгөөний үйл ажиллагаанд 18.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон эмээл, зочид буудал, хоол, сургалтын үйл ажиллагаанд тус тус зарцуулсан.

Нийт 22 төсөл арга хэмжээнээс 1800.0 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, 517.3 сая төгрөгийн санхүүжилт авсан 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэл үр дүн хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн Засаг даргын А/604 дугаар захирамжаар хог хаягдлыг дахин боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах төслийн зээл 2 аж ахуй нэгжид 180 сая төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй эхний 24 сар хүү төлөх нөхцөлтэй 3 жилийн хугацаатай олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг зөрчсөн байна. Түүнчлэн барьцаалсан хөрөнгийг мэргэжлийн үнэлгээчнээр

¹³ “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг ойлгоно”

- үнэлүүлээгүй, Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар их хэмжээний зээлтэй байхад нэмж зээл олгосон, гэрээгээр хүлээсэн хүүгийн төлбөрөө 2022 онд төлөөгүй,
- Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20 сая мод хөтөлбөрөөс аймгийн Засаг даргын захирамжаар 192.7 сая төгрөгийг зарцуулсан ч аймгийн хэмжээнд хэчнээн хэмжээний мод хүлээн авсан баримт, модны амьдралтын хувь тооцсон, хөтөлбөрийн эдийн засгийн үр өгөөжийг тооцсон баримт материал байхгүй,
 - Мөст сумын эрүүл мэндийн төв, мооргийн барилгын засварын ажлыг Алтан бэрс интернейшнл ХХК-тай 161.8 сая төгрөгөөр 2022.12.23-нд хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан ч ажлын тоо хэмжээний дагуу гүйцэтгэж өгөөгүй гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй төлөвлөсөн үр дүнд хүрээгүй,
 - Хогны менежментийг сайжруулах төслийн дэмжлэг /хөтөлбөр/-өөс Хог хаягдлыг төлбөртэй хүлээн авах автомат "ЭКОКЭШ" төхөөрөмж 2 ширхэг нийлүүлэх ажлыг ТЕХНОЛОГИБРИДЖ ХХК-тай 12.5 сая төгрөгөөр 2022.07.30-нд хүлээн авахаар гэрээ байгуулсан боловч нийлүүлэгдээгүй гэрээ сунгаагдаагүй, гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

В.2.3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН, ХУГАЦААНД НЬ ОЛГОСОН БАЙНА.

2022 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний санхүүжилтэд 2,127.2 сая төгрөгийг хэрэгжүүлсэн 22 төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Хэрэгжүүлсэн ОНТХО-ын ажлуудаас 4 ажлын 12.7 сая төгрөгийн зургийн үнийг суутгаж гэрэгээр гүйцэтгэсэн аж ахуй нэгжийн дансанд, 15 гүйцэтгэгчтэй холбоотой 54.8 сая төгрөгийн барьцааг барьцаа хөрөнгийн дансанд, 15 ажлын 15.2 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутган тооцож тус тусын дансанд шилжүүлсэн байна.

Мөн тайлант оны эцэст 190.2 сая төгрөгийн дуусаагүй ажлын үлдэгдэл, худалдан авах ажиллагааны хэмнэлт, зарцуулаагүй үлдэгдлийг барьцаа дансанд байршуулжээ.

В.2.4. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЯНАЛТЫН ТАЙЛАН МЭДЭЭ БАЙХГҮЙ БАЙНА.

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн хяналтын тайлантай танилцахад ОНТХО-аар хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тайлан, мэдээ, зураг байхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.1¹⁴, 5.2.2¹⁵, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1¹⁶, 35.1.1¹⁷, 35.1.4¹⁸, 35.1.6¹⁹ 37 дугаар зүйлийн 37.1²⁰, 37.1.4²¹ 37.1.9²² гэж тус тус зааснаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх заалтыг зөрчсөн байна.

Их засварын ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлтэй тулган хянахад захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчил илэрч байна.

¹⁴ "Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ",

¹⁵ "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах,

¹⁶ "Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ",

¹⁷ "нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих",

¹⁸ "тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах",

¹⁹ "барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах",

²⁰ "Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ,

²¹ "барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах",

²² "барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах"

Аудитын илрүүлэлт

- Үенч сумын сургуулийн дотуур байрны засвар Буянт ундрах шим ХХК 121.6 сая төгрөг /дээврийн ус зайлуулах хоолой хөлдсөнөөс хайлсан цасны ус дээвэрт нэвчсэн, хамгаалалтын төмөр бэхлэгээ муу хийгдсэнээр салсан байдалтай байна./
- Жаргалант өрхийн эмнэлгийн дотор халаалт, бохир, гадна цэвэр усны шугам сүлжээний засвар /Ховд дулааны станц ТӨХК 20.8 сая төгрөгөөр хийсэн боловч халаалт өмнөх жилээс сайжраагүй/

В.2.5 ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУДЫГ ХҮЛЭЭН АВАХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХДАА ХУУЛЬ, ЖУРМЫГ МӨРДӨӨГҮЙ БАЙНА.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас Засаг даргын нөөц сангаас бэлтгэж, ЗДТГ-ын данс бүртгэлд бараа материалаар бүртгэж, журмын дагуу иргэд, малчдад олгож байх шаардлагатай дараах төсөл арга хэмжээнүүд байна. Тухайлбал “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт”, “Гэрэлт ирээдүй” хүүхдийн тэтгэмж “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ” гэх мэт төсөл арга хэмжээ байна.

Төсөл арга хэмжээг хүлээн авах ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлүүд давтагдсаар байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн аюулгүй нөөцөд ногоон тэжээл, овьёос, хүчит тэжээл бэлтгэхээр Засаг даргын орлогчтой байгуулсан гэрээ, Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпораци, Агаар халаагч тоног төхөөрөмж нийлүүлэх Ховд дулааны станцын ажлыг комисс томилж ашиглалтад хүлээж авсан баримт материал байхгүй байна.
- Шинэ Ховд агро парк” төслийн хүрээнд усалгаатай газар тариалангийн усан хангамжийн эх үүсвэр гаргах зорилгоор Буянт сумын Норжинхайрхан багт гаргасан 83 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худаг гаргах ажлыг Топ дриллинг ХХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан байхад орлогод авч бүртгээгүй байсныг аудитын явцад залруулж бүртгэлд авхуулсан болно.

Аудитаар нийт 6,456.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 765.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, 5,691.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 11 зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ӨМНӨХ ОНУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АУДИТААР ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖИЖ БАЙГААТАЙ ХОЛБООТОЙ ТЕЗ-Д АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДААГҮЙ, ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ, ЧАНАРТАЙ ХИЙГДЭЭГҮЙГЭЭС АШИГЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ГОМДОЛ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ШҮҮМЖЛЭЛ ТАСРАХГҮЙ БАЙНА..

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Аймгийн Засаг дарга Э.Болормаа -д зөвлөх нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг журмын холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, үнэлж, эрэмбэлэн журмын хэрэгжилтийг ханган ажиллах

2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ батлуулахгүй байх.

Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ч.Багдал-д

1. УТХО-ын болон ОНХО-аас хэрэгжиж байгаа ТАХ-ны техник хяналтын зардлыг эх үүсвэр бүрээр бүртгэл хөтөлж, зориулалт бусаар зарцуулахгүй байх.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Түмэндэмбэрэл -д

1. Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож байх.

2. Байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг эргэн хянаж, биелэлтийг тухай бүр нь хангуулах, ТАХ ажлын гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлсэн үед улсын комиссын актыг баталгаажуулж, эцсийн санхүүжилтийг олгож байх.

3. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 20 сая мод хөтөлбөрөөс аймгийн хэмжээнд хэчнээн хэмжээний мод хүлээн авсан тайлан гаргах, модны амьдралын хувь тооцох, хөтөлбөрийн эдийн засгийн үр өгөөжийг тооцох.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэцэцэг-т

1. Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн ерөнхий шаардлагыг тавьж, техникийн тодорхойлолтын дагуу боловсруулж тендерт оролцогчдод ижил тэгш оролцох боломжийг олгох.

2. Тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан оролцогчийг сонгон шалгаруулах, ТБОНӨХБАҮХАТ хууль, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

3. Төсөвлөлтийн ерөнхий шаардлага хангаагүй, зураг төсөв ТЭЗҮ батлагдаагүй, зураг төсөв нь магадлалаар орж батлагдаагүй төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байх.

4. Ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг баримт бичгийг бүрдүүлэн данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын түр орлон гүйцэтгэгч Б. Төгөлдөр-т,

1. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын чанар ашиглалтын шаардлага хангаагүй, Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандарттай нийцэхгүй байгаа зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР